



МАТНХ, "АТУТ" ТӨҮГ, НТГ-Т

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251

Утас: (976-51) 26 71 68, Факс: (976-11) 31 23 15,

Цахим шуудан: info@mrtд.gov.mn,

Цахим хуудас: www.mrtд.gov.mn

*2023-08-08* № *07/538*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хэлэлцээр хүргүүлэх тухай**

Автотээврийн салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын хөдөлмөрлөх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, үйл ажиллагааны харилцан үр ашигтай байдлыг хангах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол тээвэр холбоо газрын тосны ажилтны ҮЭ-үүдийн холбоо, "Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбоо" ТББ-тай харилцан тохирч байгуулсан "Автотээврийн салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамтын (тариф)-ын хэлэлцээрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд бүртгүүлснийг үүгээр хүргүүлж байна.

Дээрх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт.....хуудастай.

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН  
ДАРГА *М.Сүхбаатар* Ё.ЖАРГАЛСАЙХАН



080000709

Боловсруулсан: Намсравал  
Хянасан: Мрн  
Хувь: 4  
Огноо: 2013.02.02

005000000

БАТЛАВ:



МОНГОЛЫН ТЭЭВЭР  
ХОЛБОО ГАЗРЫН ТОСНЫ  
АЖИЛТНЫ ҮЭ-ҮҮДИЙН  
ХОЛБООНЫ ДАРГА



МОНГОЛЫН  
АВТОТЭЭВЭРЧДИЙН  
НЭГДСЭН ХОЛБООНЫ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



**АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ЗӨВШЛИЙН ГУРВАН ТАЛТ 2023-2025 ОНЫ  
ХАМТЫН (ТАРИФ)-ЫН ХЭЛЭЛЦЭЭР**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалт, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус баримтлан Автотээврийн салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын хөдөлмөрлөх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, үйл ажиллагааны харилцан үр ашигтай байдлыг хангах зорилгоор хэлэлцээрт оролцогч талууд харилцан хэлэлцэж тохирсны үндсэн дээр энэхүү хамтын хэлэлцээрийг байгуулав.
- 1.2. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн хамтын (тариф)-ын хэлэлцээр нь талууд гарын үсэг зурж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
- 1.3. Өмчийн хэлбэрээс үл хамааран автотээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад өмчийн харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн ч энэхүү хамтын хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд хэлэлцээрийн заалтуудаас илүү нөхцөлөөр тохиролцсон хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээний заалтууд хэвээр мөрдөгдөнө.
- 1.4. Байгууллагууд хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журамдаа энэхүү хамтын хэлэлцээрээр тохирсон нөхцөлүүдийг дордуулахгүйгээр тусгана.
- 1.5. Энэхүү хамтын хэлэлцээр нь авто тээврийн салбарын нийт ажилтан, ажил олгогчид хамаарна.



1.6. Талууд хамтын хэлэлцээрийн өмнө нь хүрсэн түвшинг тасралтгүй сайжруулах зарчим баримтална.

## **ХОЁР. ЦАЛИН ХӨЛС, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР**

2.1. Гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авдаг ажилтны ажлын нэгжид ногдох цалингийн үнэлгээг төрийн болон хувийн хэвшлийн салбарын ажилтнуудын дундаж цалин, хэрэглээний зүйлийн үнэ, тарифын өөрчлөлт болон инфляцын өсөлттэй уялдуулан тухай бүр индексжүүлж нэмнэ.

2.2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн дагуу Автотээврийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлснээс багагүй байхаар тогтооно. Хэрэв хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоосон тохиолдолд өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөнө.

2.3. Ажилтны сарын нийт цалингийн 70-аас дээш хувь нь үндсэн цалин байна.

2.4. Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлсэн, албан тушаалын тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгүүлсэн бол үндсэн цалингийн 50 хувиас доошгүй хувиар тооцож нэмэгдэл хөлс олгоно.

2.5. Мэргэжлээрээ ажиллаж буй салбарын мэргэшсэн инженер, зөвлөх инженер, докторын зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-30% хүртэл хэмжээгээр олгоно.

2.6. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосноор хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болсон ажилтанд буцалтгүй тусламж өгөх асуудлыг байгууллагын хамтын гэрээ, дотоод журамд тусгаж хэрэгжүүлнэ.

2.7. Мэргэшсэн жолооч болон мэргэжлийн зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20% хүртэл хэмжээгээр нэмж олгоно.

2.8. Автотээврийн салбарын аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсан, ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн, ажилтан мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн хувьд гүйцэтгэж байгаа ажил үүрэгтээ тэнцэхгүй болох нь тогтоогдсон болон эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй нь эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр тогтоогдсон өндөр насны тэтгэвэр тогтоолгох ажилтанд дараах тэтгэмжийг олгоно. Үүнд:

- зургаан сараас хоёр жил хүртэл ажилласан бол хоёр ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх;
- хоёр жилээс тав хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх;
- таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол дөрөв ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх;

- 10 ба түүнээс дээш жил ажилласан бол тав ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх.

2.9. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа 2 хүртэл жил дутуу байгаа ажилтнуудыг цомхотголд оруулахгүй бөгөөд хэрэв тухайн ажлын байр нь хасагдсан тохиолдолд цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг дордуулахгүйгээр өөр ажилд шилжүүлж ажлын байраар хангана.

2.10. Ажил, амралтын цагийн горимыг байгууллагын ажлын онцлогтой уялдуулан Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхцөлөөс дордуулахгүйгээр баталж мөрдүүлнэ.

2.11. Ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдлийг үндсэн болон хийснээр нь олгох цалингаас бодож олгохдоо холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хамтын гэрээгээр тогтоон олгоно.

2.12. Ажилтныг олон жил, тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс ажилласан жилийн нэмэгдлийг хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж хэрэгжүүлнэ.

2.13. Ажилтныг мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмших үед ажлын байрны баталгаагаар хангана.

2.14. Автотээврийн салбарын ажилтнуудын ажлын байрны баталгааг хангах зорилгоор Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын дотоодын ажиллах хүч хангалттай тохиолдолд гадаадаас ажиллах хүчнийг авч ажиллуулахгүй байх зарчмыг баримтална.

2.15. Ажил олгогч нь аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсан, ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсний улмаас ажилтнуудыг цомхотгох, бөөнөөр халах тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулалт хийхийн зэрэгцээ Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай зөвшилцөнө.

2.16. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага зорчигч болон ачаа тээвэр эрхэлж буй аж ахуй нэгж, байгууллагатай гэрээ байгуулахдаа энэхүү хэлэлцээрийн нөхцөлүүдийг тусган хэрэгжүүлэх заалтыг тусгайлан оруулж өгнө. Уг гэрээнд төрөөс тарифыг зохицуулж оруулбал үнийн зөрүүг аж ахуйн нэгж, байгууллагуудад хугацаанд нь бүрэн олгоно. Хэрэв Хөдөлмөрийн тухай хууль, Автотээврийн тухай хууль, бусад хууль, дүрэм болон энэхүү хамтын хэлэлцээрт заагдсан нөхцөлүүдийг удаа дараа зөрчвөл гэрээг цуцлах арга хэмжээг талууд холбогдох газарт тавьж шийдвэрлүүлнэ.

2.17. Аж ахуйн нэгж байгууллага, хоршооллын зүгээс ачаа болон нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хөнгөлөлттэй зээл авах, парк шинэчлэлтийг хийхэд төрийн захиргааны төв байгууллага болон нийслэл хотын зүгээс уг үйл ажиллагааг явуулах нөхцөл бололцоогоор хангаж, дэмжлэг үзүүлэх тал дээр талууд хамтран ажиллана.

## **ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛ АМРАЛТЫН ГОРИМ ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР**

3.1. Нийтийн тээврийн компаниудад олгож буй нөхөн олговор, машин цагийн зардал, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүү



хуваарилалтын талаарх мэдээллийг хэлэлцээрт оролцогч талуудад улирал бүр мэдээлэх, түүний мөрөөр талууд үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг авна.

3.2. Төрийн захиргааны болон төрийн өмчит байгууллагын удирдах ажилтны ажлын байрны тодорхойлолтод тавигдах мэргэжлийн шаардлагыг салбарын мэргэжилтэй байхаар заах ба түүнд нийцсэн иргэнийг сонгон шалгаруулж томилох, улс төрийн аливаа нөлөөллөөс ангид байлгах, албан тушаалаас нь хууль бусаар чөлөөлсөн, шилжүүлсэн тохиолдолд талууд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авна.

3.3. Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийн санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт суулгах талаар талууд хамтарч ажиллана.

3.4. Ажилтнаас үл шалтгаалах сул зогсолтын хугацаанд түүнийг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол түүнд үндсэн цалингийнх нь 70 буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний олговор олгоно.

3.5. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн зогсоолд жолооч, зорчигчдын амрах, хооллох, бие засах стандартын шаардлага хангасан барилга, байгууламжийг гэрээнд тохиролцсоны дагуу байгуулах бөгөөд үүнтэй холбоотой гарах зардлыг Нийслэлийн төсөвт тусгах талаар хамтран ажиллана.

### **ДӨРӨВ. АЖИЛТНУУДЫН МЭРГЭЖИЛ, БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

4.1. Ажил олгогч нь ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулна.

4.2. Салбарын ажилтнуудын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр талууд их дээд сургууль, сургалтын төвүүдтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулах, түүнд хөнгөлөлттэй нөхцөлөөр сургах талаар тусган хэрэгжилтийг хангуулна.

4.3. Автотээврийн салбарын ажилтнуудыг гадаад, дотоодын сургалт, семинарт хамруулах, 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно.

4.4. Гадаад харилцааны шугамаар зохион байгуулагдах арга хэмжээнд хэлэлцээрт оролцогч байгууллагуудын төлөөллийг оролцуулж туршлага судлуулна.

4.5. Мэргэшсэн жолоочийн сургалтын чанарыг сайжруулж, шалгалтыг цахимаар зохион байгуулах ажлыг боловсронгуй болгоно.

4.6. Ажилтнуудын хоол, унааны нэмэгдлийг олгох асуудлыг тухайн байгууллага хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусган хэрэгжүүлнэ. Мөн ханшийн өсөлттэй уялдуулан тухай бүр шийдвэрлэх арга хэмжээ авна.

4.7. Ажилтнуудыг амьдрах орчноо сайжруулахад дэмжлэг үзүүлэх ажлыг тухайн байгууллага хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусган хэрэгжүүлнэ.

- 4.8. Ажил олгогчоос ажилтнуудыг мэргэжлийн хариуцлагын болон бусад төрлийн даатгалд ажил мэргэжлээс хамааран даатгуулах арга хэмжээ авна.
- 4.9. Ар гэрийн гачигдал гарсан, ажилтнуудын гэр орон гал усны болон байгалийн давагдашгүй хүчин зүйл онц ноцтой аюулд учирсан тохиолдолд мөнгөн тусламж үзүүлэх асуудлыг тухайн байгууллага хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусган хэрэгжүүлнэ.
- 4.10. Ажилтанд түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлэх талаар хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж хэрэгжүүлнэ.
- 4.11. Тээврийн байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдыг орон сууцжуулах зорилгоор орон сууцны хөнгөлөлтөд хамруулах, орон сууцны газар олгох, тухайн баазын эзэмшил өөрийн нөөц бололцоотой газарт орон сууц барих эрхийг олгох, дэмжлэг үзүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг талууд хэрэгжүүлэх талаар хамтран ажиллана.
- 4.12. Тээврийн байгууллага, аж ахуйн нэгж бүр тухайн жилийн төсөвт ажилтнуудыг орон байраар хангах талаар хамтын гэрээ, дотоод журамд тодорхой зааж тусган хэрэгжүүлнэ.
- 4.13. Автотээврийн байгууллагад ажиллаж байсан харьяалалгүй ахмадуудыг холбогдох тээврийн байгууллагын харьяалалд оруулах арга хэмжээг талууд авна.
- 4.14. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, ганц бие, хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй ахмадуудад тусламж, дэмжлэг үзүүлдэг "Ахмадад ээлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд"-ыг урамшуулна.
- 4.15. Автотээврийн салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, ажлын туршлага, мэдээлэл солилцох арга хэмжээг талууд хамтран зохион байгуулна.
- 4.16. Байгууллагын болон автотээврийн салбарын нэрийн өмнөөс улс, хотын чанартай урлаг, спортын тэмцээн, уралдаанд оролцон амжилт гаргасан ажилтныг шагнаж урамшуулна.
- 4.17. Автотээврийн салбарын аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын дунд спортын наадам, уралдаан тэмцээнийг жил бүр, урлагийн наадмыг 2 жил тутамд хамтран зохион байгуулна.

#### **ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГЫГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР**

- 5.1. Аж ахуйн нэгж, байгууллага улс, хот хооронд ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх жолооч нарыг замд гарахаас өмнө эмнэлгийн үзлэгт хамруулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, ослын үед хэрэглэх багаж, хэрэгслээр хангана.
- 5.2. Автотээврийн салбарын ажлын байруудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хөдөлмөрийн нөхцөлийн судалгааг хийж, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл нь хэвийн бус гэж тогтоогдсон ажил мэргэжлийг холбогдох эрх зүйн хэм

хэмжээний актад нэмж тусгуулах, ажлын цагийг богиносгох, ээлжийн нэмэгдэл амралтыг олгох талаар арга хэмжээ авна.

5.3. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудыг жилд 2-оос доошгүй хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудыг жилд нэгээс доошгүй удаа эмнэлгийн бүрэн үзлэгт хамруулна.

5.4. Халдварт өвчин, цар тахал гарсан тохиолдолд ажилтнуудын эрүүл мэнд, амь насыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

5.5. Аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны эрүүл ахуйн орчныг бүрдүүлэх, сайжруулах болон ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулна.

5.6. Ажилтнуудын эрхлэх ажлын онцлогоос хамааран хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөр хамгааллын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүн, ариутгах, цэвэрлэх, угаах бодисоор үнэгүй хангахын зэрэгцээ хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны жагсаалтыг баталж мөрдүүлж хэвшсэн байна.

5.7. Ажлын цагийн ачаалал, хөдөлмөрийн таатай бус нөхцөлөөс үүдэн гарсан ослыг үйлдвэрлэлийн осолд тооцуулдаг тогтолцоог бий болгох асуудлаар талууд хамтран судална.

5.8. Албан үүргээ гүйцэтгэх явцад үйлдвэрлэлийн осолд өртсөн ажилтныг оношлуулах, эмчлүүлэх зардлыг байгууллагаас гаргана.

5.9. Үйлдвэрлэлийн осол гаргаагүй аж ахуйн нэгж, байгууллага болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг сайжруулах ажлыг үлгэр жишээ зохион байгуулсан ажилтныг урамшуулах арга хэмжээ авна.

5.10. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Зам тээврийн ажилчдын ажил ба амралтын цагийн үргэлжлэх хугацааны тухай" 153 дугаар конвенцод нэгдэн орох асуудлыг шийдвэрлэх, үүнтэй холбогдон гарах зардлыг гурван талын төлөөлөл бүрэн хариуцна.

5.11. Салбарын хэмжээнд ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх ажилтнуудыг амь нас, эрүүл мэндийн болон хариуцлагын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна.

5.12. Талууд үндэсний ажил мэргэжил, ангилал, тодорхойлолт YAMAT-08 ороогүй ажил мэргэжлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд уламжилж тусгуулах тал дээр хамтран ажиллана.

5.13. Автотээврийн салбарын ажилчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулах тал дээр хамтран ажиллана.

5.14. Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо нь автотээврийн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт семинар тогтмол зохион байгуулах ба сургалттай холбоотой зардлыг холбогдох байгууллагуудын төсөвт тусгуулж ажиллана.

#### **ЗУРГАА. ҮЭ-ИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР**

- 6.1. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээг авч ажиллана.
- 6.2. Тухайн байгууллага нь үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн ҮЭ-ийн дарга, ажилтныг өөрийн байгууллагын ажилтны нэг адил хамтын гэрээнд хамруулан шагнал урамшуулал, нийгмийн баталгаа, хөнгөлөлтөд хамруулна.
- 6.3. ҮЭ-ийн гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн ҮЭ-ийн татварыг бэлэн бусаар хурааж, дансанд нь шилжүүлэх үүргийг тухайн байгууллага хүлээнэ.
- 6.4. Төрийн байгууллага болон аж ахуй нэгж, байгууллагууд нь хамтын гэрээ хэлэлцээр хийхэд шаардлагатай мэдээллийг Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажлын 15 хоногийн дотор өгнө.
- 6.5. Салбарын ажилтнуудын эрх ашигтай холбоотой аливаа шийдвэр гаргах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ салбарын ҮЭ-ийн байгууллага, бусад холбогдох төрийн бус байгууллагуудын саналыг авч, оролцоог хангаж ажиллана.
- 6.6. Ажил олгогч нь Үйлдвэрчний эвлэлийн хороодыг ажиллах нөхцөл бололцоогоор /өрөө тасалгаа, хурал, уулзалт хийх байр, шаардлагатай судалгаа, мэдээлэл, холбогдох шийдвэр, дүрэм, журам/ хангана.
- 6.7. Автотээврийн салбарын шугамаар зохион байгуулагдах сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд салбарын байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн, сонгуультнуудыг оролцуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.
- 6.8. Үйлдвэрчний эвлэлийн ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хамтарсан сургалт, үзлэг, шалгалт хийх, Хөдөлмөрийн тухай, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай болон хөдөлмөрийн харилцаатай холбогдох бусад хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, гишүүдийг Үйлдвэрчний эвлэлийн сургалтад хамруулахад салбарын холбооны албан бичгийг үндэслэн цалинтай чөлөө олгоно.
- 6.9. Ажлын байрыг олноор цомхотгох, хөдөлмөрийн нөхцөлийг дордуулахад хүргэх орон тоо, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийх тохиолдолд аж ахуйн нэгж байгууллага /ажил олгогч/ нь холбогдох үйлдвэрчний эвлэлийн байгууллагад урьдчилан мэдэгдэж, харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагад бичгээр мэдэгдэнэ.
- 6.10. Байгууллагын түвшинд тухайн жилийн цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой төсвийн төсөл боловсруулах, зарцуулах асуудлаар Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын саналыг харгалзана.
- 6.11. Салбарын ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төслийг боловсруулж хэрэгжүүлэхдээ тухайн ажил олгогчдын болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагын оролцоог хангаж ажиллана.
- 6.12. Автотээврийн салбарын ажил, үйлчилгээний үнэ тарифыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь ажил олгогчид зохих дэмжлэг үзүүлнэ.

## **ДОЛОО. НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

- 7.1. Төрийн захиргааны төв байгууллага нь автотээврийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн зөвлөгөөнийг 2 жилд нэг удаа зохион байгуулна.
- 7.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 7.3. Салбарын үндсэн ажилтнуудыг орон сууцаар хангах зорилгоор орон сууц барих, хөнгөлөлттэй зээлд хамруулах, төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж болно.
- 7.4. Талууд автотээврийн салбарын ажиллагсдын цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох, тооцоо судалгааг үндэслэн нийтлэг ажил мэргэжлүүдийн тарифт цалинг тогтоох талаар хамтран ажиллана.
- 7.5. Автотээврийн тухай хууль, түүнийг даган гарах дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар хэлэлцээрийн талууд хамтарч санал боловсруулна.
- 7.6. Нийтийн тээврийн үйлчилгээнд зуучлалын шинж чанартай ажил, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгж, байгууллагын зохисгүй үйлдлийг таслан зогсоох арга хэмжээг хамтран зохион байгуулна.

## **НАЙМ. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ТАЛААР**

- 8.1. Хамтын хэлэлцээрт тусгасан асуудлыг хугацаанд нь биелүүлэх үүргийг гэрээг байгуулсан талууд хариуцна. Талууд хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийн явцыг жил тутам дүгнэж, хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээ авч хамтран ажиллана.
- 8.2. Салбарын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо нь салбарын нийт ажилтныг төлөөлөн, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалагчийн хувьд хамтын хэлэлцээрт туссан асуудал бүрийг хугацаанд нь биелүүлэхийг шаардах эрхтэй ба хэрэгжилтийн явц байдлыг төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогчийн төлөөлөлд мэдээлэх үүрэгтэй.
- 8.3. Хэлэлцээрийг сурталчлах, мэдээлэх асуудлыг талууд хариуцаж ажиллана.
- 8.4. Талууд харилцан тохиролцсоноор хамтын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд хэлэлцээрийн талуудад ажлын 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэж шийдвэрлэнэ.
- 8.5. Автотээврийн салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2022-2024 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.
- 8.6. Хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд талууд шинээр санал гаргаагүй, хэлэлцээр байгуулаагүй бол дараагийн хэлэлцээр байгуулагдах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

---000---




ХАМТЫН ТАРИФ/-ЫН ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

1. Ё.Жаргалсайхан 

ЗТХЯ-ны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

2. З.Чүнсэрээ 

ЗТХЯ-ны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

3. Д.Оюунсүрэн 

ЗТХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

4. С.Нансалмаа 

ЗТХЯ-ны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

5. С.Жавхлантбаатар 

Нийтийн тээврийн газрын дарга

6. Б.Гүрсоронзон 

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирал

АЖИЛТНЫГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛЫН ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗРЫН ТОСНЫ АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ХОЛБОО

1. Ц.Ариунбаатар 

Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын ажилтны ҮЭ-ийн хорооны дарга

2. Б.Мөнхболд 

Нийслэлийн нийтийн тээврийн газрын ажилтны ҮЭ-ийн хорооны дарга

3. Д.Ариун-Эрдэнэ 

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын ҮЭ-ийн хорооны дарга

4. Ц.Батчулуун 

Хувиараа тээвэр эрхлэгчдийн ҮЭ-ийн нэгдсэн хорооны дарга

5. П.Баттулга 

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын ажилтны ҮЭ-ийн хорооны дарга

6. Б.Номин-Эрдэнэ 

Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны ҮЭ-үүдийн холбооны хуулийн мэргэжилтэн

АЖИЛ ОЛГОГЧДЫГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛЫН АВТОТЭЭВЭРЧДИЙН НЭГДСЭН ХОЛБОО

- |                 |   |  |
|-----------------|---|--|
| 1. А.Цэцэгмаа   |    | “Төмөрлөг машин үйлдвэрлэл инженерингийн холбоо”-ны тэргүүн                |
| 2. В.Ёндонжамц  |    | “Хот хоорондын тээвэр эрхлэгчдийн холбоо” -ны тэргүүн                      |
| 3. Ц.Хишигсүрэн |    | “Нүүрсний автотээврийн компаниудын “Хайрхан холбоо” НҮТББ-ын тэргүүн       |
| 4. Э.Чимэддагва |    | Монголын тээврийн ирээдүй холбооны тэргүүн                                 |
| 5. Н.Адъяацэрэн |   | “Өмнөговь аймгийн Автотээвэрчдийн нэгдсэн холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал |
| 6. Ж.Аюуш       |  | Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбооны тээвэр хариуцсан менежер         |